



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар Б/26

Модот

О.Алтанзулд тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын үйлчлэгч О.Алтанзул нь бага насны 5-н хүүхэдтэй, мөн эрүүл мэндийн шалтгаантай эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлж байгаа иймд ар гэрт нь дэмжлэг үзүүлэх шаардлага гарсан тул хамт олны хурлын шийдвэрийг үндэслэн нэг удаагийн мөнгөн тусламж олгосугай.

2. Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 780000 төгрөгийг олгохыг Санхүү албаны Нягтлан бодогч (Г.Уянга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.НАВЧАА